



“БАДРАХ ЭНЕРЖИ АКАДЕМИ”

“Бадрах Энержи Академи” хөтөлбөрийн талаар

- “Бадрах Энержи Академи” гэдэг нь ураны салбарын шинэ үеийн мэргэжилтнүүдийг бэлтгэх хагас жилийн хөтөлбөр юм.
- Хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа: 2026 оны 1-6 дугаар сар
- Оролцогчид техникийн хэлтэс болон хэрэгжиж байгаа төслийн орчинд ажлын туршлага хуримтлуулж мөн олон улсад ч сургалтын хөтөлбөрт хамрагдах боломжтой.

Хөтөлбөрийн онцлог:

- Байгаль орчин, геологи, гидрогеологи, үйлдвэрлэлийн болон химийн процесс, аюулгүй байдал ба цацрагийн хамгаалалт, олборлолт үйлдвэрлэл зэрэг хэлтэст ээлжлэн туршлага хуримтлуулах боломжтой
- Туршлагатай инженер болон супервайзоруудаар менторлуулах боломж
- Унаа, байр, хоол болон эрүүл мэндийн даатгалын зардлыг компаниас хангана
- Хөтөлбөрийн туршид гадаад хэлний болон манлайллын сургалтад хамрагдана
- Орано группийн уул уурхайн салбаруудад болон олон улсын түвшинд ажлын туршлага солилцох, суралцах боломжтой.

Оролцогчдод тавигдах шаардлага:

- Бакалаврын хөтөлбөрийн төгсөх курсийн оюутан
- Магистрын хөтөлбөрийн оюутан
- Шинэ төгсөгч (ажлын туршлага шаардагдахгүй)
- Ураны салбарт карьераа хөгжүүлэх эрмэлзэлтэй байх

“Бадрах Энержи Академи” хөтөлбөрт дараах мэргэжлийхэн хамрагдах боломжтой:

- Уул уурхайн инженер болон үйлдвэрлэл боловсруулалт
- Процесс ба химийн инженер
- Механик ба засвар үйлчилгээний инженер
- Цахилгаан ба хэмжилзүйн инженерчлэл
- Аюулгүй байдал ба цацрагийн хамгаалалт
- Байгаль орчин ба тогтвортой хөгжил
- Геологийн шинжлэх ухаан

Бүрдүүлэх материал:

1. Өөрийн намтар 1-2 нүүр

2. **Эрмэлзлээ илэрхийлсэн товч захидал бичиж ирүүлэх (ихдээ 1 нүүрт багтааж “Бадрах Энержи Академи”-д хамрагдах болсон шалтгаан, энэ нь таны ирдээгүйн карьер хөгжилтэй хэрхэн холбогдож байгааг тайлбарлах)**

Материалаа дараах хаягаар g-orn-hrbadrakhenergy@orano.group 2025 оны 12 дугаар сарын 10-аас өмнө явуулна уу.

Хөтөлбөр дараах үе шатаар хэрэгжиж, **нийт 10 оюутан, залуучуудыг сонгон** хамруулна.

2025 оны 10-12 дүгээр сар	Хүсэлт хүлээн авна
2025 оны 12 дугаар сар	Хүсэлттэй танилцаж, ярилцлага хийнэ
2026 оны 1-6 дугаар сар	Хөтөлбөрт ээлжээр хамрагдана (14×14 ээлж)
2026 оны 6 дугаар сар	Хөтөлбөр өндөрлөж, залуу мэргэжилтнүүдэд ажлын байр санал болгоно.

Танд амжилт хүсье!